



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 41

Сүхбаатар сум

Үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "г", Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.2.1-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс зардлыг хариуцах мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Малын халдварт шөвөг яр, адууны томуу, сахуу зэрэг өвчний урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан тарифаар тооцож аж ахуйн нэгж, малчид, иргэдээс гаргуулсугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, сумдын хувийн хэвшлийн мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдэд даалгасугай.

ДАРГА  БЯМБАА



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2018 оны 04 дугаар сарын 05-ны
өдрийн.....тогтоолын хавсралт



**ТӨСВӨӨС ЗАРДЛЫГ ХАРИУЦАХ МАЛ ЭМНЭЛЭГ,
ҮРЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ
ЖИШИГ ҮНЭЛГЭЭ**

| № | Ажил үйлчилгээний нэр | Хэмжих нэгж | 2008 онд баталсан /төг/ | 2008 оны улсын дундаж /төг/ | 2012 онд мөрдөх санал /төг/ |
|---|------------------------------|-------------|-------------------------|-----------------------------|-----------------------------|
| Нэг.Мал эмнэлгийн ажил үйлчилгээ | | | | | |
| 1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга | | | | | |
| 1 | Бод | Тол.тутам | 150 | 225 | 500 |
| | Бог | Тол.тутам | 100 | 151,4 | 450 |
| | Гахай, бусад тэжээвэр амьтад | Тол.тутам | 150 | 225 | 500 |
| | Бүх төрлийн шувуу | Тол.тутам | 150 | 151,4 | 500 |
| 2.Лабораторийн шинжилгээнд дээж авах | | | | | |
| 2 | Цусны дээж авах | Нэг дээж | 160 | 250 | 550 |
| 3.Оношлох шинжилгээ | | | | | |
| 3 | Сорил тарих | Тол.тутам | 400 | 500 | 650 |
| Хоёр.Мал үржлийн ажил үйлчилгээ | | | | | |
| 1.Ангилалт | | | | | |
| 1 | Бод | | 500 | | 500 |
| 2 | Бог | | 250 | | 250 |
| Ашиг шимийн гарц тодорхойлох ноос ноолуур | | | | | |
| 3 | Тэмээ | | 300 | | 300 |
| 4 | Бог | | 150 | | 150 |
| Сүү | | | | | |
| 5 | Бод | | 200 | | 200 |
| 6 | Бог | | 100 | | 100 |
| Үзлэг, заазлалт хийх | | | | | |
| 7 | Бод | | 400 | | 400 |
| 8 | Бог | | 300 | | 300 |
| А.Шивүүрээр дугаарлах | | | | | |
| 9 | Бод | Тол.тутам | 150 | | 500 |
| 10 | Бог | Тол.тутам | 300 | | 400 |
| Б.Ээмэг зүүж дугаарлах | | | | | |
| 11 | Бод | Тол.тутам | 150 | | 500 |
| 12 | Бог | Тол.тутам | 80 | | 300 |
| В.Малын жин тодорхойлох | | | | | |
| 13 | Бод | Тол.тутам | 150 | | 200 |